

# Карибын эрдэнэс

Ахмад Джек нууц эрдэнэсийн агуйд ортол тэнд  $n$  ширхэг авдар байжээ. Авдар бүр өөр өөрийн өнгөтэй сувдаар дүүрэн байсан (нэг авдарт байгаа сувднууд адил өнгөтэй, өөр авдарт байгаа сувднууд ялгаатай өнгөтэй).  $i$ -р авдарт  $m_i$  ширхэг сувд байна. Тэр дор хаяж  $a$  ширхэг сувд авч явахыг хүсч байгаа ба  $b$ -гээс олон сувд даахгүй. Ингээд Джек хэдэн ширхэг, хэдэн өнгийн сувд авч явахыгаа шийдэж чадахаа байжээ. Тэр хэдэн янзаар сувдуудыг авч явж чадах вэ?

Дараах үйлдлүүдийг гүйцэтгэх програм бич:

- оролтоос авдар бүрт байх сувдны тоо болон  $a$ ,  $b$  тоог унших
- Джек хэдэн янзаар сувднуудыг сонгон авч явж болохыг тооцолох
- үр дүнг гаргах

## Input

Оролтын эхний мөрөнд  $n$ ,  $a$ ,  $b$  бүхэл тоонууд зайгаар тусгаарлагдан байрлана ( $1 \leq n \leq 10$ ,  $0 \leq a \leq b \leq 10\,000\,000$ ). Дараагийн  $n$  ширхэг мөр тус бүрд нэг бүхэл тоо байна.  $i+1$ -р мөрөнд байгаа бүхэл тоо нь  $m_i$  буюу  $i$ -р авдранд байх сувдны тоог илэрхийлнэ ( $0 \leq m_i \leq 1\,000\,000$ ).

## Output

Джекийн сувднуудыг авч явах ялгаатай боломжуудын тоо нь  $k$  байг. Гаралт дээр байх ёстой ганц бүхэл тоо нь  $k \% 2007$  гэсэн утгатай байна ( $k$  тоог 2007-д хуваасны үлдэгдэл).

## Example

**Input:**

```
2 1 3
3
5
```

**Output:**

```
9
```

Тайлбар. Джек сувднуудыг дараах байдлаар авч явж чадна:

(1, 0), (2, 0), (3, 0), (0, 1), (0, 2), (0, 3), (1, 1), (1, 2), (2, 1)